



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/102

Есөнбулаг

Хамтарсан хяналт, шалгалт
хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.3 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чандмань сумын Зээгтийн уурхайд ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг "Сэкер ресорсус монголиа" ХХК-д холбогдох хууль журмын хэрэгжилт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар зэрэг хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хамтарсан хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	А. Дэлгэржаргал (Аймгийн Засаг даргын зөвлөх)
Гишүүд:	Т. Ууганжаргал (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Хууль эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга)
	Л. Хаш-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
	Д. Эрхэмбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн уул уурхай хариуцсан улсын ахлах байцаагч)
	П. Золбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн хууль тогтоомжийн биелэлт, хууль, шүүхийн байгууллагын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
	Ж. Төгөлдөр (Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны дарга)
	Г. Болдбаатар (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Д. Батмагнай (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Хүрээлэн буй орчин,

- байгалийн нөөцийн хэлтсийн дарга,
улсын ахлах байцаагч
- Д. Гаадамба (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын
удирдлагын хэлтсийн дарга)
- П. Ууганбаатар (Аймгийн цагдаагийн газрын
Эрүүгийн цагдаагийн тасгийн
экологийн асуудал хариуцсан
эрүүгийн ахлах мөрдөгч,
цагдаагийн ахмад)
- Н. Дашдаваа (Аймгийн Татварын хэлтсийн жижиг
татвар төлөгчтэй харилцах тасгийн
татварын улсын байцаагч)
- Б. Содмаа (Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын ус ашиглалт, төрийн бус
байгууллага хариуцсан ахлах
мэргэжилтэн, улсын байцаагч)
- С.Дөлгөөн (Тагнуулын ерөнхий газрын ерөнхий
газрын аймаг дахь хэлтсийн
ажилтан)
- Ч. Эрдэнэ-Очир (Чандмань сумын Засаг дарга)
- Б. Өлзийсайхан (Чандмань сумын Засаг даргын
Тамгын газрын Байгаль орчны
улсын байцаагч)
- Нарийн бичгийн дарга: Б. Цэрэнбал (Аймгийн Засаг даргын Тамгын
газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн уул уурхай, байгаль
орчин, аялал жуулчлалын бодлого
хариуцсан мэргэжилтэн)

2. Хяналт шалгалтыг холбогдох хуульд нийцүүлэн гүйцэтгэж, үр дүнг Засаг даргын Удирдлагын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсэг (А.Дэлгэржаргал)-т даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

